

Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус Цаг Уур, Орчны Судалгаа, Мэдээллийн Хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Цаг Агаар, Орчны Тоон Загварчлал Судалгааны Хэлтэс (ЦАОТЗСХ)-ээс 2023 оны 2 дугаар сараас 4 дүгээр саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг [Цаг агаар \(tsag-agaar.gov.mn\)](http://tsag-agaar.gov.mn) цахим хуудсанд сар бүрийн 28-нд шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг Уурын Байгууллага (ДЦУБ)-аас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11–326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ЦАОТЗСХ-ээс тодруулах боломжтой.

Хоёр. ТОЙМ

2.1 2 – 4 дүгээр сарын уур амьсгал

Агаарын температур II сард Баян–Өлгий, Увс, Завхан, Хөвсгөлийн ихэнх, Архангайн баруун, Сэлэнгийн хойд, Төвийн зүүн хойд хэсгээр -22...-28°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн өмнөд хэсэг болон Өмнөговийн ихэнх нутгаар -8...-14°C, бусад нутгаар -14...-22°C хүйтэн байдаг. III сард Баян–Өлгийн баруун өмнөд, Увсын хойд, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Хөвсгөлийн баруун хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр -14...-18°C, Ховдын хойд болон өмнөд, Говь-Алтай, Дундговийн ихэнх, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутгаар 0...-6°C, бусад нутгаар -6...-14°C хүйтэн байдаг. Харин IV сард Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр -2...-8°C хүйтэн, Ховдын хойд болон өмнөд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд, Дундговь, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар 4...10°C дулаан, бусад нутгаар 2 градус хүйтнээс 4 градус дулаан байдаг.


Хур тунадасны хувьд II сард Завханы зүүн, Архангайн өмнөд, Хөвсгөлийн баруун хойд, Сэлэнгийн зүүн, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 2–4 мм, бусад нутгаар 0–2 мм, III сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 4–6 мм, бусад нутгаар 0–4 мм, IV сард Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 6–10 мм, бусад нутгаар 0–4 мм хур тунадас ордог байна.

Гурав. 2023 ОНЫ 2–4 ДҮГЭЭР САРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2023 оны II сараас 2023 оны IV сарын цаг агаарын мэдээ

Хоёрдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Увс, Завхан, Хөвсгөлийн ихэнх, Архангайн баруун, Сэлэнгийн хойд, Төвийн зүүн хойд хэсгээр -22...-28°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн өмнөд хэсэг болон Өмнөговийн ихэнх нутгаар -8...-14°C, бусад нутгаар -14...-22°C хүйтэн байдаг байна.


2 дугаар сарын агаарын дундаж температур Өмнөговь, Дундговь, Дорноговийн нутаг, Сүхбаатарын өмнөд хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 1**).



Зураг 1. 2 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)
[Д – агаарын температур ОЖД–аас дулаан, Н – агаарын температур ОЖД–ийн орчим]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Завханы зүүн, Архангайн өмнөд, Хөвсгөлийн баруун хойд, Сэлэнгийн зүүн, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 2–4 мм, бусад нутгаар 0–2 мм хур тунадас ордог.


2 дугаар сарын нийлбэр хур тунадас Баян–Өлгий, Увс, Ховд, Говь–Алтай, Өмнөговийн нутаг, Завханы баруун, Баянхонгор, Өвөрхангай, Дундговь, Дорноговийн өмнөд хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (**Зураг 2**).



Зураг 2. 2 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
[Н – хур тунадас ОЖД–ийн орчим, Б – хур тунадас ОЖД–аас бага]

Гуравдугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгийн баруун өмнөд, Увсын хойд, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Хөвсгөлийн баруун хойд, Архангайн баруун, Төвийн зүүн хойд хэсгээр -14...-18°C, Ховдын хойд болон өмнөд, Говь-Алтай, Дундговийн ихэнх, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд, Өмнөговь, Дорноговийн нутгаар 0...-6°C, бусад нутгаар -6...14°C хүйтэн байдаг байна.


3 дугаар сарын агаарын дундаж температур Баян–Өлгийн нутаг, Ховд, Говь–Алтай, Баянхонгорын өмнөд, Өмнөговийн баруун хэсгээр ОЖД–аас хүйтэн, Төв аймгийн зүүн, Дундговийн зүүн хойд, Дорноговийн хойд хэсэг болон Хэнтий, Дорнод, Сүхбаатарын нутгаар ОЖД–аас дулаан, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 3**).



Зураг 3. 3 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв (°C)
[Д – агаарын температур ОЖД–аас дулаан, Н – агаарын температур ОЖД–ийн орчим]
Х – агаарын температур ОЖД–аас хүйтэн]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 4–6 мм, бусад нутгаар 0–4 мм хур тунадас ордог байна.


3 дугаар сарын нийлбэр хур тунадас Баян–Өлгий, Өмнөговийн нутаг, Ховд, Говь–Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, Булган, Сэлэнгэ, Төв, Хэнтийн нутаг, Дорнодын ихэнх хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 4**).



Зураг 4. 3 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
 [И–хур тунадас ОЖД–аас ахиу, Н – хур тунадас ОЖД–ийн орчим, Б – хур тунадас ОЖД–аас бага]

Дөрөвдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр $-2...-8^{\circ}\text{C}$ хүйтэн, Ховдын хойд болон өмнөд, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангайн өмнөд, Дундговь, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар $4...10^{\circ}\text{C}$ дулаан, бусад нутгаар 2 градус хүйтнээс 4 градус дулаан байдаг.


Дөрөвдүгээр сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД–аас дулаан байх төлөвтэй байна (**Зураг 5**).



Зураг 5. 4 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв ($^{\circ}\text{C}$)
 [Д – агаарын температур ОЖД–аас дулаан]

Сарын нийлбэр хур тунадас ОЖД–аар Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг болон Дорнодын тал нутгаар 6–10 мм, бусад нутгаар 0–4 мм хур тунадас ордог байна.

4 дүгээр сарын нийлбэр хур тунадас Өмнөговь, Дундговь, Дорноговийн нутгаар ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас бага байх төлөвтэй байна (**Зураг 6**).



Зураг 6. 4 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв (мм)
 [Н – хур тунадас ОЖД–ийн орчим, Б – хур тунадас ОЖД–аас бага]

3.2 Зөвлөмж

Агаарын дундаж температур хоёрдугаар сард ихэнх нугаар, гуравдугаар сард нутгийн зүүн хэсгээр, дөрөвдүгээр сард нийт нутгаар ОЖД–аас дулаан байх бол гуравдугаар сард баруун болон говийн аймгуудын нутгийн баруун хэсгээр ОЖД–аас хүйтэн, бусад хугацаанд бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна.

Хур тунадас хоёрдугаар сард баруун болон говийн аймгуудын ихэнх хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим, гуравдугаар сард нутгийн баруун өмнөд хэсгээр ОЖД–аас ахиу, зүүн хойд хэсгээр дунджаас бага хур тунадас орох бол бусад нутгаар дунджийн орчим байх төлөвтэй байна. Харин дөрөвдүгээр сард ихэнх нутгаар дунджаас харьцангуй бага хур тунадас орох төлөвтэй байгаа ч говийн бүс нутгаар дунджийн орчим байх магадлалтай байна.

Хаврын саруудад ихэнх хугацаанд ихэнх нутгаар дунджаас дулаан, хур тунадас багатай байх төлөвтэй байгаа буюу хуурайшил их байж, салхи шуурга ихтэй байх магадлал өндөр байна.